



МОНГОЛ УЛСЫН ТУХАЙН ХЭВГЭЛ  
1 тэмдэг 06 дугаар сарын 24  
№24 /693/

ᠮᠣᠩᠭᠣᠯ

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛТ

Монгол Улсын  
хууль

1082

Монгол Улсын Их  
Хурлын тогтоол

1085

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

1094

**Ашигт малтмалын хайгуулын  
тусгай зөвшөөрөл шинээр  
олгохыг хориглох тухай**

**Үндэсний үйлдвэрлэгчдийг  
дэмжих, ажлын байр  
нэмэгдүүлэх зарим арга  
хэмжээний тухай**

**Хэлэлцээр батлах тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |  |      |
|------|--|------|
| 257. | Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  | 1078 |
| 258. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай  | 1082 |
| 259. | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шингэр олгохыг хориглох тухай   | 1082 |
| 260. | Далайн нэхэмжлэлийн харилцаагьг хөгжгэрлэх тухай 1976 оны олон улсын Конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1996 оны Протоколд нэгдэн орох тухай | 1083 |
| 261. | Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллагын 1976 оны Конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1981 оны Протоколд нэгдэн орох тухай              | 1083 |
| 262. | Хөлөг онгоцны гэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай 2004 оны олон улсын Конвенцид нэгдэн орох тухай                    | 1083 |
| 263. | Хөлөг онгоцны гадаргуут хамгаалах системд хортой бодис ашиглахыг хянах тухай 2001 оны олон улсын Конвенцид нэгдэн орох тухай                             | 1084 |
| 264. | Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлгэх иргэний харилцаагьн тухай 2001 оны олон улсын Конвенцид нэгдэн орох тухай   | 1084 |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |      |  |                   |
|------|--|-------------------|
| 265. | Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 30<br>1085 |
| 266. | Хуулийн төсөл буцаах тухай   | Дугаар 31<br>1086 |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- |      |                                  |                    |
|------|----------------------------------|--------------------|
| 267. | Засгийн газарт чиглэл өгөх тухай | Дугаар 117<br>1087 |
|------|----------------------------------|--------------------|

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |   |                    |
|------|---|--------------------|
| 268. | Засгийн газрын тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 114<br>1087 |
|------|---|--------------------|



269.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 115	1093
270.	Хэлэлцгэр батлах тухай	Дугаар 125	1094
271.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 126	1094
272.	Уул уурхайн аврах албаны талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 128	1101
<b>МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ</b>			
273.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 01	1102

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 05 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

### МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.1.4 дэх заалт нэмсүгэй:

“4.1.4.эмийн ургамлыг тарималжуулсан тохиолдолд сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг үйлдвэрлэх, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгж.”

**2 дугаар зүйл.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “ашиглах,” гэсний өмнө “үйлдвэрлэх,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтын “кино,” гэсний дараа “дуу,” гэж, 13.1.3 дахь заалтын “эмийг” гэсний дараа “жоргүйгээр болон хүчингүй жороор олгох, түүнчлэн” гэж, 13.1.8 дахь заалтын “зөвшөөрөлгүйгээр” гэсний дараа “импортлох, экспортлох,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын



эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт:**

"4.1.3.харьцуулалт хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага."

**2/5 дугаар зүйл:**

**"5 дугаар зүйл.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх**

5.1.Эмчилгээний зорилгоор хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг улсын стандартын шаардлага хангасан жороор олгоно.

5.2.Хүн амын тоог харгалзан мансууруулах эмээр үйлчлэх эрх бүхий эмийн сангийн тоо, байршлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тогтооно."

**3/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:**

"6.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тухай бүрд энэ тухай хилийн мэргэжлийн хяналтын алба мэргэжлийн хяналтын төв байгууллагад 7 хоногийн дотор мэдэгдэнэ."

**4/8 дугаар зүйл:**

**"8 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөл олгох**

8.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг энэ хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад зориулалтаар үйлдвэрлэх, худалдах, ашиглах, хэрэглэхийг хориглоно.

8.2.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг үйлдвэрлэх, эм ханган нийлүүлэх байгууллагын худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

8.3.Энэ хуулийн 4.1-д заасан зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг гарган авахад ашигладаг химийн бодисыг ашиглах,

импортлох тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.3-т заасны дагуу олгоно.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай зөвшөөрөл авахыг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хадгалах шаардлага, тусгай нөхцөлийг хангасан агуулахтай байх бөгөөд уг агуулахын талаар мэргэжлийн хяналтын байгууллага дүгнэлт гаргана.

8.5.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрлийг гурван жилийн хугацаатай олгоно.

8.6.Тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиар тус тус зохицуулна."

#### **5/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:**

"9.1.Тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэл, импорт, ашиглалт, зарцуулалт, хэрэгцээний тайланг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө гарган эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллага болон энэ хуулийн 14.5-д заасан Үндэсний хороонд тус тус ирүүлнэ."

#### **6/13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт:**

"13.1.4.эмчилгээнд хэрэглэх жагсаалтад орсноос бусад мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмсэр үйлчлэх."

#### **7/13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалт:**

"13.1.6.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг иргэн эмчийн заавар, жоргүйгээр хэрэглэх."

#### **8/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

"14.1.Мэргэжлийн хяналтын байгууллага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын бүртгэл, хуваарилалт, үйлдвэрлэл, зарцуулалт, хадгалалт, худалдаа хэрэглээ хуульд заасан журамд нийцэж байгаа эсэхэд болон түүхий эдийн олборлолт, ургамлын тархацад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна."

**9/14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг:**

"14.5.Энэ хуулийн 14.1-14.4-т заасан байгууллагын авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байна.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно."

**10/16 дугаар зүйлийн 16.1.1,16.1.2 дахь заалт:**

"16.1.1.энэ хуулийн 13.1.7, 13.1.8, 13.1.10 дахь заалтыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.2.энэ хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.4, 13.1.5 дахь заалтыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох."

**4 дүгээр зүйл.**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Эмийн тухай" хууль," гэснийг "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль," гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын "эмнэлэг," гэснийг "эрүүл мэндийн болон" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн "эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас авсан" гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 05 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.4 дэх заалтын "импортлох" гэсний дараа "экспортлох" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 5 дугаар сарын 26-ны өдөр баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуульд заасан хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хориглосугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ДАЛАЙН НЭХЭМЖЛЭЛИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ 1976 ОНЫ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИ БОЛОН ТҮҮНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН 1996 ОНЫ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Олон улсын далайн байгууллагын "Далайн нэхэмжлэлийн хариуцлагыг хязгаарлах тухай" 1976 оны олон улсын Конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1996 оны Протоколд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ДАЛАЙН ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН 1976 ОНЫ КОНВЕНЦИ БОЛОН ТҮҮНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН 1981 ОНЫ ПРОТОКОЛД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Далайн хиймэл дагуулын олон улсын байгууллагын 1976 оны Конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1981 оны Протоколд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ХӨЛӨГ ОНГОЦНЫ ТЭНЦВЭРЖҮҮЛЭГЧ УС БОЛОН ҮЛДЭГДЭЛ ТУНАДАСНЫ ХЯНАЛТ БА МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ 2004 ОНЫ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Олон улсын далайн байгууллагын "Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн





тухай” 2004 оны олон улсын Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨЛӨГ ОНГОЦНЫ ГАДАРГУУГ ХАМГААЛАХ  
СИСТЕМД ХОРТОЙ БОДИС АШИГЛАХЫГ ХЯНАХ  
ТУХАЙ 2001 ОНЫ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИД  
НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Олон улсын далайн байгууллагын “Хөлөг онгоцны гадаргууг хамгаалах системд хортой бодис ашиглахыг хянах тухай” 2001 оны олон улсын Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨЛӨГ ОНГОЦНЫ ШАТАХУУНЫ САВНЫ  
ТОСНЫ БОХИРДЛООС УЧИРСАН  
ХОХИРЛЫН ТӨЛӨӨ ХҮЛЭЭХ ИРГЭНИЙ  
ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ 2001 ОНЫ ОЛОН  
УЛСЫН КОНВЕНЦИД НЭГДЭН  
ОРОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Олон улсын далайн байгууллагын “Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай” 2001 оны олон улсын Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2011 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот**Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих,  
ажлын байр нэмэгдүүлэх зарим  
арга хэмжээний тухай**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгоход зориулан 100 /нэг зуун/ тэрбум төгрөгийн, хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд 2011 онд төрөөс олгох мөнгөн урамшуулалд болон ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэгчдэд 50 /тавин/ тэрбум төгрөгийн, жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд зориулан 150 /нэг зуун тавин/ тэрбум төгрөгийн, нийт 300 /гурван зуун/ тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаасыг гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан нэгдүгээр зэргийн хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 2000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгох;

2/2011 онд хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгосон мөнгөн урамшуулал болон энэ тогтоолын 3 дахь заалтад заасан Монголбанкны урьдчилан төлсөн хүүгийн зөрүүг буцаан олгохтой холбогдсон зардлыг 2012 оны улсын төсөвт тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;

3/хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хонины болон тэмээний ноос бэлтгэлд мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага,



Засгийн газрын үнэт цаасны санхүүгийн эх үүсвэрийн болон түүхий эд бэлтгэлийн үйл ажиллагааны шат дарааллын бүдүүвчийг тогтоосон холбогдох журмын төслийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу 2011 оны эхний хагаст багтаан батлан мөрдүүлэх;

4/мал аж ахуйн гаралтай бусад түүхий эдийн дотоодын бэлтгэл болон энэ чиглэлийн үндэсний үйлдвэрүүдийг дэмжихтэй холбогдсон асуудлыг боловсруулан Улсын Их Хурлын 2011 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх.

3.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үйлдвэрлэгчид олгох зээлийн хүүг жилийн 7 хувиас илүүгүй байхаар тооцож, 2011 оны хүүгийн зөрүүг урьдчилан төлөхийг Монголбанк /Л.Пүрэвдорж/-нд үүрэг болгосугай.

4."Хоршооны гишүүн" гэсэн тодотголыг 2013 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5.Энэ тогтоолыг 2011 оны 6 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2011 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

### **Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2010 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2011 оны 06 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 117

Улаанбаатар  
хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучингуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэн батлагдсантай холбогдуулан төрийн бодлого, үйл ажиллагааг үзэл баримтлалын агуулгад нийцүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийн жагсаалтыг салбар тус бүрээр гаргаж, холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлыг "Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"-тэй уялдуулан төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;

2. Засгийн газраас гаргах шийдвэр, санаачлах хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын агуулгад нийцүүлэх, үзэл баримтлалын агуулга нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдсөн нөхцөлд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг санаачилж батлуулсны үндсэн дээр үзэл баримтлалд нийцсэн шийдвэр гаргах.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ**

**СҮХБААТАРЫН  
БАТБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 114

Улаанбаатар  
хот

### Засгийн газрын тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 32 дугаар тогтоолын 1, 3 дугаар зүйлийн "баталгаат" гэснийг "аюулгүй" гэж өөрчилсүгэй.

2. Мөн тогтоолын хавсралтын нэрийг "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөр гэж өөрчлөн, хөтөлбөрт дор дурдсан агуулга бүхий дараахь заалтыг нэмсүгэй:

1/ 11 дэх хэсгийн 11.9, 11.10, 11.11 дэх заалт:

"11.9. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх бүс нутгийн хилийн зааг, тухайн аймаг, сумын хөдөө аж ахуйн эдэлбэр газарт эзлэх хувийг тогтоох, тариалангийн газрыг ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэх нөхцөл, тариалангийн талбай, ургацыг малаас хамгаалах талаар холбогдох хуульд нэмэлт оруулах төсөл боловсруулах;

11.10. Тариалангийн даатгалын хэлбэр, тогтолцоог бий болгох, уул уурхайн салбараас олж байгаа орлогын тодорхой хувийг хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асуудлыг судалж санал боловсруулах;

11.11. Хүнсний үйлдвэрлэлд мөрдөж байгаа стандартуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах."

2/12 дахь хэсгийн 12.7, 12.8 дахь заалт:

"12.7. Хүнсний органик бүтээгдэхүүний шинэ нэр төрлийг бий болгосон, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрийг урамшуулах арга хэлбэрийн талаар судалж, санал боловсруулах.

12.8. Бордоо, бага оврын техник, т.ног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх, угсрахыг дэмжих."

3/13 дахь хэсгийн 13.7 дахь заалт:

"13.7. Газар тариалангийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн холбоог өргөтгөх."

4/ 14 дэх хэсгийн 14.7, 14.8, 14.9, 14.10 дахь заалт:

"14.7. Баруун болон зүүн бүсэд эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг сэргээн хөгжүүлэх, түүний дотор Халх голын бүс нутагт тариалангийн зориулалтаар ашиглаж болох атаршсан болон атар газрыг эргэлтэд оруулах зорилго бүхий "Халх гол" төслийг хэрэгжүүлэх;



14.8. Газар тариалангийн үйлдвэрлэлд байгаль орчинд халгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, тариалангийн талбайг хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах, хөрсний үржил шимийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

14.9. Таримал ургамлын шинэ сортыг бий болгох, нутагшуулах, сорт сорилт, судалгааны ажлыг эрчимжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулах, хүнсний гол нэрийн таримлын үр үржүүлэг, үйлдвэрлэл, нийлүүлэлтийг боловсронгуй болгох;

14.10. Нэг болон олон наст тэжээлийн ургамал, техникийн таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах замаар таримал тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хослон эрхлэх, хөдөлмөрөө хоршин ажиллахыг дэмжих.”

5/17 дахь хэсгийн 17.6, 17.7, 17.8 дахь заалт:

“17.6. Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бүс нутаг болон бүтээгдэхүүн, үйлчилгээний салбар бүрээр тэргүүлэх чиглэлийг тогтоож хэрэгжүүлэх;

17.7. Монгол брэндийн болон органик бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ-эко маркетыг бий болгох, энэ чиглэлээр гадаад, дотоод зах зээлийн судалгаа явуулж, сурталчлах арга хэмжээ авах;

17.8. Органик бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулахад чиглэгдсэн шинжлэх ухаан, технологийн төсөл, судалгаа, шинжилгээний ажилд нэн тэргүүнд дэмжлэг үзүүлэх.”

6/18 дахь хэсгийн 18.11, 18.12 дахь заалт:

“18.11. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг гарал үүсэл, эрүүл ахуйн баталгаа, хаяг, шошготойгоор зах зээлд нийлүүлэх ажлыг зохион байгуулах;

18.12. Хүнсний зориулалттай түүхий эд, бүтээгдэхүүнд хүнд металл, цацраг үүсгүүр, ургамал хамгааллын бодис, малын эм зэрэг бодисын үлдэгдлийн тандалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах.”

7/25 дахь хэсгийн 25.16 дахь заалт:

“25.16. Тариаланд шаардагдах нийт үрийн 60-80 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болж, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг



54.0 мянган га-д хүргэж, нийт ургацын 15-аас доошгүй хувийг усалгаатай талбайгаас авдаг болно.”

3. Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 11.7 дахь заалтын “хүнсний бүтээгдэхүүн” гэсний дараа “органик хүнс,” гэж, 12.2 дахь заалтын “татаас” гэсний дараа “урамшуулал” гэж, 14.2 дахь заалтын “иргэдэд” гэсний дараа “зуны болон өвлийн хүлэмж,” гэж, “санхүүгийн болон” гэсний дараа “мэргэжил,” гэж, 14.6 дахь заалтын “шар буурцгийн” гэсний дараа “болон мөөг, бусад түгээмэл биш хүнс, тэжээлийн ашигт таримлын” гэж, 15.2 дахь заалтын “бий болгоход” гэсний дараа “болон сүү цуглуулах, хөргөх төв байгуулах, технологи эзэмшүүлэхэд” гэж, 17.3 дахь заалтын “хүнсний ногоо” гэсний дараа “, жимс жимсгэнэ, ургамлын тос” гэж, 18.3 дахь заалтын “үйлдвэрт хэрэглэх” гэсний дараа “цэвэр өсгөврийн хөрөнгө,” гэж, 22.6 дахь заалтын “жимс жимсгэнэ” гэсний дараа “шар буурцаг,” гэж, 25.11 дэх заалтын “өндөгний” гэсний өмнө “Хүнсний ногоо,” гэж, 26.1 дэх заалтын “сүүний” гэсний дараа “болон төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний” гэж тус тус нэмсүгэй.

4. “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 9 дэх хэсэг, 7.1, 7.6, 11.4, 12.1, 14.4, 14.5, 17.4, 25.3, 25.5, 25.6 дахь заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 9 дэх хэсэг:

“9. Хөтөлбөрийн зорилго нь иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх. Монгол брэн, эг н органик хүнсийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц, э, ийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэхэд оршино.”

2/ 7.1 дэх заалт:

“7.1. “хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид эрүүл ахуйн баталгаатай хүнсийг нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үл хамааран жигд, тогтвортой, хүртээмжтэй хэрэглэх боломж бүрдсэн байхыг.”

3/ 7.6 дахь заалт:

“7.6 “хүнсний эрүүл ахуй” гэж хүнс бэлтгэх, боловсруулах, сэллэх, хадгалах, тээвэрлэх, экспортлох, импортлох, худалдах, үйлчлэх явцад хүний эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байх нөхцөл хангагдсан байхыг.”



## 4/ 11.4 дэх заалт:

"11.4. Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, Монгол хүний хоол тэжээлийн физиологийн нормыг мөрдүүлэх."

## 5/ 12.1 дэх заалт:

"12.1. Импортоор хангаж байгаа хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн, түүхий эд болон хүнсний боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгааны болон зоорийн тоног төхөөрөмж, хүлэмж, элеватор, бордоо, ургамал хамгааллын болон хөрсний чийг хадгалагч бодисийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг судалж, санал боловсруулах."

## 6/ 14.4 дэх заалт:

"14.4. Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ургамлын тос, өндөг, загасны хангамжийг тогтворжуулах зорилгоор дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх."

## 7/ 14.5 дахь заалт:

"14.5. Тариалангийн техник шинэчлэл, усалгаатай тариалан, бордоо, ургамал хамгаалал, механикжсан зоорь, үр тарианы агуулах, зуны болон өвлийн хүлэмж, үрийн шинэчлэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон урамшуулал олгох;"

## 8/ 17.4 дэх заалт:

"17.4. Органик хүнсний үйлдвэрлэлийг урамшуулан дэмжих, тэдгээрийг эрх бүхий олон улсын байгууллагаар баталгаажуулах, үндэсний болон олон улсын түвшинд Монголын газар зүйн заалттай бүтээгдэхүүнд бүртгүүлэх арга хэмжээ авах."

## 9/ 25.3 дахь заалт:

"25.3. Хүн амын мах, сүү, гурил, буудай, төмсний хэрэгцээг бүрэн, хүнсний ногооны 80, өндөгний 65-70, цецгийн тосны 15, загасны 15, ургамлын тосны 5-10 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангадаг болсон байна."

## 10/ 25.5 дахь заалт:



"25.5. Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 42.0 мянган га-д хүргэж, нийт ургацын 10-аас доошгүй хувийг усалгаатай талбайгаас авдаг болно."

11/ 25.6 дахь заалт:

"25.6. Тариаланд шаардагдах нийт үрийн 30-40 хувийг I-III зэргийн үрээр тариалдаг болж, таримлын нэр төрөл, сэлгээний ээлжийн тоо нэмэгдэнэ."

5. Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн 10.1.8 дахь заалтын "чанар, аюулгүй байдлыг" гэснийг "эрүүл ахуйн баталгааг" гэж, 10.1.10 дахь заалтын "аюулгүй байдлыг" гэснийг "эрүүл ахуйг" гэж, 10.2 дахь заалтын "аюулгүй" гэснийг "эрүүл ахуйн баталгаатай" гэж, 10.3 дахь заалтын "эрүүл ахуй, аюулгүй байдлыг" гэснийг "эрүүл ахуйн баталгааг" гэж, 11.3 дахь заалтын "эрүүл, экологийн цэвэр," гэснийг "органик," гэж, 13.2 дахь заалтын "аюулгүй байдлын" гэснийг "эрүүл ахуйн" гэж, 13.6 дахь заалтын "хангамж, тэжээллэг чанар, аюулгүй байдлын асуудлыг" гэснийг "аюулгүй байдлыг" гэж, 14.6 дахь заалтын "төсөл хэрэгжүүлж" гэснийг "зорилгоор" гэж, 18.9 дэх заалтын "Чанар, аюулгүй байдлын" гэснийг "Эрүүл ахуйн" гэж, 19.1 дэх заалтын "аюулгүй байдлын" гэснийг "эрүүл ахуйн" гэж, 22.4 дэх заалтын "аюулгүй" гэснийг "эрүүл ахуйн баталгаатай" гэж, 23.1 дэх заалтын "баримтлах бодлого" гэснийг "дэд хөтөлбөр" гэж, 24.1 дэх заалтын "баталгаат" гэснийг "аюулгүй" гэж, 24.6 дахь заалтын "баталгаат" гэснийг "аюулгүй" гэж, 26.6 дахь заалтын "аюулгүй байдлын" гэснийг "эрүүл ахуйн" гэж тус тус өөрчилсүгэй.

6. Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн 10.1, 10.1.1 дэх заалтуудын "хангамж, чанар," гэснийг, 10.1.9, 11.5 дахь заалтуудын "чанар," гэснийг, 19.4 дэх заалтын "чанар, аюулгүй байдал" гэснийг, 24.3 дахь заалтын "бүтэц, зохион байгуулалтын" гэснийг тус тус хассугай.

7. Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн 12.3, 12.4, 12.5, 14.3, 18.1 дэх заалтуудыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

8. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар тэтгэлгээр баталсан "Засгийн газрын комисс, үндэсний хороо, ажлын хэсэг, тэдгээрийн дарга" гэсэн 20 дугаар хавсралтын 48 дугаар зүйлийн "Хүнсний баталгаат байдал" гэснийг "Хүнсний аюулгүй байдал" гэж өөрчилсүгэй.



9. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 50 дугаар тогтоол, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 93 дугаар тогтоол, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 239 дүгээр тогтоол, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 283 дугаар тогтоол, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 70 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Т.БАДАМЖУНАЙ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 4 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар  
хот

### **Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны хооронд 2011 оны 3 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан "БНСУ-д ажилчид илгээх тухай" харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсаас БНСУ-д ажиллах хүч илгээх ажлыг төрийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр заасантай холбогдуулан "Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай" Засгийн газрын 2007 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 36 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 177 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гадаадад ажиллах хүч илгээх төв" ХХК-тай холбогдолтой асуудлыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Т.ГАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 125

Улаанбаатар  
хот

### Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2011 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Бүгд Найрамдах Кипр Улсын Никоса хотод гарын үсэг зурсан "Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Кипр Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 126

Улаанбаатар  
хот

### Хөтөлбөр батлах тухай

Шуудангийн тухай хуулийн 7.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Өрх бүрт шуудан" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Өрх бүрт шуудан" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороотой хамтран боловсруулж зохих журмын дагуу батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Бат-Эрдэнэд даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тухайн жилийн төсвийн төсөлд тусгах, хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын банк,

санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогт, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Бат-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хороо (Б.Болдбаатар)-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2011 оны 126 дугаар  
тогтоолын хавсралт

### **“ӨРХ БҮРТ ШУУДАН” ХӨТӨЛБӨР**

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Монгол Улсад шуудангийн үндсэн сүлжээг бий болгох, үндсэн сүлжээний дамжуулах чадварыг сайжруулж, сүлжээгээр дамжих уламжлалт үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж мэдээллийн технологид тулгуурласан шинэ нэр төрлийн үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлэх, шуудангийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, найдвартай хүргэх боломжийг бий болгоход энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Шуудангийн тухай хуулийн 7.1.2-т шуудангийн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.25-д “Мэдээлэл холбооны дэд бүтцийг өргөтгөн шинэчилж, мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээг өргөжүүлж, өрх бүрт хүртээмжтэй болгоно” гэсэн зорилгыг дэвшүүлсэн.

Монгол Улсын шуудангийн салбарын хөгжлийг гадаад орны жишигт хүргэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, үйлчилгээг иргэдэд ойртуулах, хаягийн хүргэлтийг нэмэгдүүлэх, zip кодыг хаягийн системтэй уялдуулах, шуудангийн үндсэн сүлжээг бий болгон оновчтой зохион байгуулах, шуудангийн үндсэн сүлжээгээр дамжуулан төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний найдвартай, шуурхай байдлыг хангах боломжийг бүрдүүлэх зэрэг асуудлыг энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.



Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

3.1.1. шуудангаар үйлчилэгч байгууллага, төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллага, иргэд, олон нийтийн идэвх, оролцоог сайжруулах;

3.1.2. төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурлах;

3.1.3. мэргэжлийн боловсон хүчний хангамжийг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх;

3.1.4. хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дүгнэх хариуцлагын тогтолцоо бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үндсэн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна:

4.1. Нэгдүгээр зорилт: Шуудангийн салбарт шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлэх, үндсэн сүлжээг бий болгох чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

4.2. Хоёрдугаар зорилт: Шуудангийн үндсэн сүлжээг бий болгох, ашиглалт, дамжуулах чадварыг өргөтгөн сайжруулах.

4.3. Гуравдугаар зорилт: Шуудангийн үйлчилгээнд мэдээллийн технологид тулгуурласан шинэ нэр төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх.

4.4. Дөрөвдүгээр зорилт: Шуудангийн хаягуулалтыг zip кодтой уялдуулан сайжруулах, өрх бүрийг шуудангийн хайрцагаар хангах, шуудангийн үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх.

4.5. Тавдугаар зорилт: Шуудангийн маркийн үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлж, филателийн үйлчилгээг өргөжүүлэх.

4.6. Зургадугаар зорилт: Салбарын хүний нөөц, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх.

Хөтөлбөрийн зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.7. Шуудангийн салбарт шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлэх, үндсэн сүлжээг бий болгох чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.7.1. шуудангийн салбарт гэрч байгаа шинэ техник технологи, олон улсын чиг хандлага, шуудангийн сүлжээний оновчтой, өртөг бага зарцуулах хувилбар бүхий технологийг судалж үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх;

4.7.2. Дэлхийн шуудан холбооны болон Ази, Номхон далайн бүсийн шуудан холбооны байгууллагын Үндсэн дүрэмд өөрчлөлт орсон нэмэлт протоколыг зохих журмын дагуу баталгаажуулах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

4.7.3. улс хоорондын шуудангийн илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийн журмыг Дэлхийн шуудан холбооны конвенцитай уялдуулан хэрэгжүүлэх;

4.7.4. Дэлхийн шуудан холбооны болон олон улсын санхүүгийн байгууллага, гадаад орнуудаас хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг авах;

4.7.5. шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, энэ талаар гадаадын зөвлөх мэргэжилтэн, мэргэжлийн судалгааны багийн зөвлөмж авах;

4.7.6. шуудангийн илгээмжийг ялган боловсруулах, хүргэх, тээвэрлэхэд оролцогч талуудад зориулан Дэлхийн шуудан холбоо болон бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргах;

4.7.7. бүх нийтийн үйлчилгээг давуу эрхийн бүстэй уялдуулан шинэчлэн тодорхойлох.

4.8. Шуудангийн үндсэн сүлжээг бий болгох, ашиглалт, дамжуулах чадварыг өргөтгөн сайжруулах хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.8.1. шуудангийн үндсэн сүлжээний өнөөгийн байдал, бүтэц, зохион байгуулалтыг судлан боловсронгуй болгож, дамжуулах, нэвтрүүлэх чадавхийг нь тодорхойлох;

4.8.2. шуудангийн үндсэн сүлжээг бий болгох, техник технологийн шинэчлэлт хийх, үндсэн сүлжээний автопаркийг шинэчлэх,



агаарын тээвэрээр хүргэх боломжтой алслагдсан орон нутагт шуудангийн үйлчилгээг онгоцоор хүргэх;

4.8.3. хот хоорондын болон орон нутгийн шуудангийн хүргэлтийг бүсчилсэн тогтолцоонд шилжүүлэн зохион байгуулах хувилбарыг боловсруулан хэрэгжүүлэх, шуудан солилцооны бүсийн төв байгуулах;

4.8.4. сүлжээний явцуу дамжлага, давхардлыг арилган дамжуулах, нэвтрүүлэх чадавхийг дээшлүүлж, шууданг долоо хоногт аймгийн төвд 2-оос доошгүй, сум, багт 1-ээс доошгүй удаа хүргэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

4.8.5. сүлжээгээр дамжих ачаа тээвэр, ложистик үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөн сайжруулах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурах бичгийг тээвэрлэн хүргэх.

4.9. Шуудангийн үйлчилгээнд мэдээллийн технологид тулгуурласан шинэ нэр төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх гуравдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.9.1.хэвлэлийн электрон хүргэлт, электрон худалдаа, үйлчилгээний систем бий болгох;

4.9.2. гибрид шуудангийн үйлчилгээг нэвтрүүлэх;

4.9.3.цахим шуудангийн хайрцгийн үйлчилгээг нэвтрүүлэх;

4.9.4. шуудангийн бүртгэл, тооцоо, үйлчилгээний ажлын байрыг хэвлэх төхөөрөмж, компьютер болон бусад шаардлагатай техник хэрэгслээр хангах;

4.9.5.шуудангийн үйлчилгээний лангууг тодорхой үе шаттайгаар компьютержүүлж, ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, үндсэн сүлжээнд холбох;

4.9.6."Бөөний худалдааны сүлжээ"-нд түшиглэн өргөн хэрэглээний барааны цахим худалдааг хөгжүүлэх замаар алслагдсан орон нутгийн иргэдийг өргөн хэрэглээний бараагаар хангах үйлчилгээг нэвтрүүлэх.

4.10.Шуудангийн хаягжуулалтыг zip кодтой уялдуулан сайжруулах, өрх бүрийг шуудангийн хайрцагаар хангах, шуудангийн үйлчилгээний



хэрэглээг нь нэмэгдүүлэх дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.10.1. өрх бүрийг шуудангийн хайрцагаар хангах төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

4.10.2. шинээр ашиглалтад орж байгаа нийтийн болон хувийн орон сууцанд шуудангийн хайрцаг байрлуулах;

4.10.3. zip кодоод суурилсан цахим шуудангийн хайрцаг төсөл боловсруулан хэрэгжүүлэх, цахим шуудангийн сан бүрдүүлэх талаар санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

4.10.4. томоохон супермаркет, шатахуун түгээх станц, хороодод шуудангийн хайрцаг байрлуулах;

4.10.5. zip кодтой уялдуулан албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хашаа, байшингийн нэр, дугаарыг нэг загварын хаягтай болгох, хотын гудамж, талбайг хаягжуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулах.

4.11. Шуудангийн маркийн үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлж, филателийн үйлчилгээг өргөжүүлэх тавдугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.11.1. маркийн сэдэв сонголт, борлуулалтын үйлчилгээг дэлхийн жишигт хүргэх талаар олон улсын туршлагаас судалж, нэвтрүүлэх;

4.11.2. улсын фондын маркийн нөхөн хангалтыг сайжруулах;

4.11.3. шуудангийн жижиг хэрэглэгдэхүүний /дугтуй, богц, хайрцаг, ил захидал/ үйлдвэрийг байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

4.11.4. тарифын маркийн хэрэглээ, нөөцийг судалж, шуудангаар үйлчлэгч байгууллагын маркийн хэрэглээг нэмэгдүүлэх;

4.11.5. цахим маркийн хэрэглээг бий болгож, маркийг интернетээр борлуулахад дэмжлэг үзүүлэх.

4.12. Салбарын хүний нөөц, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх зургадугаар зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:





4.12.1. шуудангийн мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ хангалтад дүн шинжилгээ хийж, шуудангийн ажил мэргэжлийг давхар болон дангаар эзэмших боломжоор нь ангилан сургаж бэлтгэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;

4.12.2. мэргэжилтэй боловсон хүчнийг гадаад, дотоодын их, дээд, тусгай мэргэжлийн сургуульд бэлтгэх;

4.12.3. шуудангийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах.

**Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт,  
санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, түншлэлийг өргөжүүлэх, оролцогч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг жил бүр Засгийн газарт тайлагнах асуудлыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар хариуцна.

5.2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын хандивлагч байгууллага гадаад орон болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дэмжлэгийг авч ажиллана.

5.3. Хөтөлбөрийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.3.1. хувийн хөрөнгө оруулалт;

5.3.2. төсвийн хөрөнгө;

5.3.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламж;

5.3.4. бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгө;

5.3.5. бусад эх үүсвэр.

5.4. Хөтөлбөрийг 2010-2020 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

5.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг нэгтгэн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийн чиглэл өгч олон нийтэд мэдээлэх, сурталчлах чиг үүргийг шуудан, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 4 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 128

Улаанбаатар  
хот**Уул уурхайн аврах албаны талаар авах  
зарим арга хэмжээний тухай**

Газрын хэвлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт уул уурхайн бүтээгдэхүүний олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад гарч болох аливаа аваар ослоос урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах, ослын үр дагаврыг шуурхай арилгах чиглэлээр Эрдэс баялаг, эрчим хүчний яамны харьяа Уул уурхайн аврах албаны бүтэц, зохион байгуулалтыг одоогийн орон тоонд нь багтаан өөрчлөн зохион байгуулж, тус албаны чадавхийг бэхжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.

2. Уул уурхайн аврах албаны албан хаагчдад тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, баталгаа, тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

3. Гадаад орны уул уурхайн аврах байгууллагын туршлага судлах, аврах албаны ажилтнуудыг давтан сургах, мэдлэг чадварыг дээшлүүлэн аврах ажиллагаанд зайлшгүй шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах хөрөнгийг жил бүр Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД****Д.ЗОРИГТ**



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2011 оны 06 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Хувь хүний орлогын албан татварын тухай  
хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалт  
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх  
тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 12.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Зол-Ундрах, түүний өмгөөлөгч Х.Баасанжаргал, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн нар оролцов.

Хуралдаанаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтад "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого." гэж заасны "...банк, санхүүгийн байгууллагаас авсан..." гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэв.

**Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Зол-Ундрах 2011 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэлдээ:**

"2006 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдаж, 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн албан татвараас чөлөөлөх орлогын зохицуулалт болох 16 дугаар зүйлийн 16.1.12-т: "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн



хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого,"-оос татварын чөлөөлөлт эдлүүлнэ гэж хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөгдөх тухай заасан байдаг. Гэтэл хувь хүн анх удаа зээлийн хөрөнгөөр орон сууцтай болж, татвараас чөлөөлүүлье гэхэд уг хуулийн дээр дурдсан "...банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр..." гэсэн заалт нь тухайн этгээдийн банк санхүүгийн байгууллага бус, өөр этгээдээс буюу ажил олгогч байгууллагаасаа авсан зээлийн хөрөнгөтэй тэнцэх орлогод ногдох татварын чөлөөлөлтөд хамрагдах боломжгүй байхаар хуульчилсан байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дээрх зүйл заалттай холбогдуулан хувь хүний орлого олж болох эрх зүйн үндэс боломжуудыг судлаад үзвэл Монгол Улсын Иргэний хуулийн зээлийн гэрээний зохицуулалт болох 281 дүгээр зүйлийн 281.1 дэх хэсэгт "Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ" гэж заасан байна. Мөн тус хуульд зээлдэгч, зээлдүүлэгчийг тодорхойлохдоо зээлдүүлэгч нь зөвхөн "банк санхүүгийн байгууллага" байхаар зохицуулаагүй. Ингэж зохицуулах ч боломжгүй. Харин тус хуулийн 451 дүгээр зүйлээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох харилцааг нарийвчлан зохицуулсан байдаг. Энэ зохицуулалтыг ойлгож хэрэглэхдээ зээлийг зөвхөн банк болон банк бус санхүүгийн байгууллага олгоно гэж байгаа мэтээр Татварын алба үзэж хэрэглэх хууль зүйн үндэслэлгүй юм. Татварыг зөвхөн хуулиар ногдуулах, чөлөөлөх татварын эрх зүйн үндсэн зарчмаар татварын албаны албан хаагчид хандаж, татварын хуулиудыг хэрэглэж байгаа гэж ойлгогдох учраас тэдний үйл ажиллагааг шууд буруутган үгүйсгэх аргагүй болж байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1,12 дахь заалтаар "... банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр..." гэж онцгойлон заасан байгаа нь татварын хуулийн уг заалтын дагуу хувь хүн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас л зээл аваагүй бол хууль ёсоор, гэрээний үндсэн дээр өөр бусад этгээдээс зээлээр олж авсан өөрийн хөрөнгөд ногдох орлогоосоо татварын чөлөөлөлт эдлэх эрхгүй харагдаж байна. Энэ нь татварын хуулиар зээлийн хөрөнгийн эх үүсвэрт ялгавартай хандсанаас Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хувь хүний эдлэх ёстой үндсэн эрх зөрчигдөж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1,12-д заасан "...хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр..." гэсэн хэсгийн "банк, санхүүгийн

байгууллагаас” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн болох нь тухайн хувь хүний хөрөнгө, орлогын хууль ёсны эх үүсвэрт үндэслэлгүй ялгаварлал тогтоосноороо банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл авсан хүмүүст татварын чөлөөлөлт эдлэх боломж олгоод харин эдгээрээс бусад этгээдээс зээл авч хөрөнгөтэй болсон хувь хүнд үйлчлэхгүй байхаар зохицуулсан байна. Хууль хүн бүрт тэгш үйлчлэх Үндсэн хуулийн зарчим, заалт ноцтой зөрчигдсөнийг нэн даруй засч залруулахад анхаарах нь ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг хайрлан хамгаалах учиртай хүн бүрийн эрхэм үүрэг мөн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.” гэж заасан байдаг. Аливаа хувь хүн ажилладаг байгууллагаасаа орон сууцны зээл аваад, тэр зээлийнхээ хөрөнгөд ногдох орлогоосоо татварын чөлөөлөлт эдлэх нь хувь хүний өөрийн өмчлөлийн зүйлээ шударгаар эзэмших, өмчлөх эдийн засгийн эрхэд хамаарна. Гэтэл татварын хуулиар хүн бүрт адил тэгш боломж олгохгүй зөвхөн банк болон банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөд ногдох орлогыг татвараас чөлөөлж байгаа нь Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн гэж үзэхэд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн адлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан байдаг. Хувь хүнд татвар ногдуулах, татвараас чөлөөлөх, хөнгөлөх эрх зүйн харилцаанд Үндсэн хуулийн дээрхи зүйл, заалтад байгаа “...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...” гэсэн хэсгийг Татварын хуулиар зөрчиж, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлж чадахгүй байгаа нь Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байна.” гэжээ.

**Хоёр. Монгол Улсын Их Хурлын даргын 2011 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 59 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

“...Улсын Их Хурлаас Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг 2006 онд шинэчлэн батлахдаа хувь хүнийг орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх зарим нөхцлийг тогтоож өгсөн. Үүний дотор хувьдаа өнх удаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад

зарцуулсан өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгийн 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний орлогыг албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн.

Хуулийн дээрх заалтад "банк, санхүүгийн байгууллагаас" гэсэн тодотгол хийсэн нь хувь хүний хөрөнгө, орлогын эх үүсвэрт үндэслэлгүй ялгавар тогтоосон, хүн бүхэнд адил тэгш боломж олгоогүй, хувь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг хангаж чадаагүй тухай мэдээлэгч тал мэдээлэлдээ дурдаад энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзжээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого" гэсэн заалтад "банк, санхүүгийн байгууллага" гэж зааснаараа үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах, эзэмших, захиран зарцуулах, төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх Үндсэн хуулийн үзэл санааг зөрчөөгүй гэж үзэж дараахь үндэслэлийг гаргаж байна.

Нэг, Татварын бодлого, түүний хөнгөлөлт, чөлөөлөлт нь эдийн засаг, нийгмийн хөгжилд зохицуулалт, дэмжлэг, урамшуулал, хязгаарлалтын үүргийг гүйцэтгэдэг төрийн зохицуулалтын онцгой арга хэрэгсэл юм. Зохицуулалтын энэ арга хэрэгсэл нь иргэдийнхээ эдийн засгийн эрх чөлөөг хангах, бүрдүүлэх, хууль зүйн баталгааг бий болгох, тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэхэд шууд чиглэгддэг.

Хүн амын орон сууцны хангамжийг сайжруулах, иргэдээ орон сууцтай болгох нь төрийн бодлогын нэг чухал хэсэг бөгөөд энэ бодлогыг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлэхдээ ил тод, иргэдэд илүү ойлгомжтой, эрсдэл багатай, найдвартай, баталгаатайгаар хэрэгжүүлэх арга замыг сонгох нь төрийн өөрийнх нь үндсэн үүрэг.

Өнөөдрийн түвшинд иргэд орон сууцны төлбөрийг бэлэн мөнгөөр төлөх төлбөрийн чадвар муу, нэн ялангуяа хадгаламжийн эх үүсвэргүй нэг талаас, нөгөө талаас санхүүгийн зах зээлд мөнгөн хөрөнгө босгоход гэрээний оролцогч талуудын хариуцлага, сахилга сул, түүнээс хүлээх эрсдэл өндөр хэвээр байгаа бодит байдалд үндэслэн санхүүгийн зах зээлд байр сууриа олсон найдвартай санхүүгийн зуучлагч



байгууллагаар дамжуулан иргэд орлогын нэг эх үүсвэрээ бүрдүүлэх, түүнд татварын чөлөөлөлт үзүүлэн дэмжих нь иргэдэд найдвартай төдийгүй хүн амаа орон сууцжуулах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд бодитой үр дүнтэй арга зам гэж үзсэнд оршиж байгаа юм. Ингэхдээ ч "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна." гэсэн Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэл болгосон.

Татвар төлөгчдөөс цуглуулсан төрийн сан хөмрөгийг татварын хөнгөлөлт чөлөөлөлт хэлбэрээр иргэддээ буцааж хөрөнгө оруулалт хийх бодлого нь иргэний өмчлөх эрхийг шударгаар олж авах эрхийг хязгаарласан бус харин өмчлөх эрхийг олж авахад төрөөс дэмжлэг үзүүлж байгаа хэлбэр мөн бөгөөд энэ утгаараа Үндсэн хуулийн Арван зургадугаар дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах" боломжийг бүрдүүлж, Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа юм.

Иргэн хүн Иргэний хуулийн 281 дүгээр зүйлд заасны дагуу иргэд хоорондоо эзэлийн гэрээ байгуулан мөнгөн хөрөнгө эзлэх замаар орон сууцтай болохыг хуулийн энэ заалтаар хориглож, хязгаарласан зүйлгүй бөгөөд харин энэ заалтаар орон сууцтай болох иргэдийн хөдөлгөөнийг өнөөдрийн санхүүгийн зах зээлийн бодит байдлын үнэлгээнд тулгуурлан урамшуулж байгаа урамшуулал, дэмжлэгийн хэлбэр юм.

Нөгөөтэйгүүр энэхүү дэмжлэгийг эрх тэгш бус байдлыг бий болгосон, шударгаар өмчтэй болох эрхийг зөрчсөн хэмээн сөргүүлэн тавих нь тухайн асуудалд илт өнгөц хандсан гэж үзэхээр байна.

Харин ч өнөөгийн түвшинд санхүүгийн зах зээлд гарч болзошгүй эрсдлийг харгалзан үзэж, хуулийн өмнө эрх тэгш байх, шударгаар өмч хөрөнгө олж авах, түүний хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд уг заалтын агуулга, мөн чанар чиглэгдэж байгаа болно.

Хоёр. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын "... банк, санхүүгийн байгууллагаас авсан..." гэж тусгайлан заасан нь Монгол Улсад орлого олж байгаа хувь хүн, хуулийн этгээд нь хэн нэгэн этгээдэд эзэл олгосон тохиолдолд Хувь хүний орлогын албан татварын тухай болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд уг олгосон эзэлээ албан татвар ногдох орлогоос хасуулах эрхтэй байдагтай ч бас холбогдолтой гэж үзэж



болно. Учир нь зээл олгох байгууллагыг тогтоож өгснөөрөө Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.12-т зааснаас бусад зээл олгогч татвар төлөгчийг Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 74, 75 дугаар зүйлтэй холбогдолтой эрсдэлд орохоос сэргийлж байдаг юм. Энэ утгаараа "...банк, санхүүгийн байгууллагаас авсан..." гэдэг нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын "...зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний..." гэж заасан хязгаарлалттай нэг санаа агуулсан, нийгэмд тэгш, шударга байдлыг хангах зорилготой урьдчилан сэргийлсэн заалт юм.

Дээр дурдсан үндэслэлүүдэд тулгуурлан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-ын "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууц барилга барих, эсхүл худалдан аваад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого" гэсэн заалтад "банк, санхүүгийн байгууллага" гэж зааснаараа Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр Танд уламжилж байна." гэсэн байна.

### ҮНДЭСЛЭЛ:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т орлогын зохих хэсгийг татвараас чөлөөлөх, хөнгөлөлт эдлүүлэхээр заахдаа тодорхой хязгаарлалт тогтоосноороо тэгш эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг хүрээнд байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12-т "...банк, санхүүгийн байгууллагаас авсан..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон





## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12 дахь заалтад "хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого." гэж заасны "...банк, санхүүгийн байгууллагаас авсан..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", Арван зургадугаар зүйлийн 3-т "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Ж.БОЛДБААТАР**

**Ж.АМАРСАНАА**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Д.МӨНХГЭРЭЛ**

**Хамт:**

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medeelal@parliament.mn](mailto:turiin_medeelal@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1

Индекс: 14003

